



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

г “Шарын гол” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд 7
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25, 42 дугаар зүйл, Үнэт цаасны бүртгэлийн журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шарын гол” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,231,389 /арван сая хоёр зуун гучин нэгэн мянга гурван зуун наян ес/ ширхэг энгийн хувьцаанаас арилжигдаагүй үлдсэн 61,147 /жаран нэгэн мянга нэг зуун дөчин долоо/ ширхэг энгийн хувьцааг хасаж нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,170,242 /арван сая нэг зуун далан мянга хоёр зуун дөчин хоёр мянга/ ширхэг энгийн хувьцаа байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үолбогдох мэдээ тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, нийтэд мэдээлэх, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Шарын гол” ХК /Б.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

000924



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Г “Шарын гол” ХК-ийн нийтэд санал болгон
нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, 34.1.7, Компанийн тухай хуулийн 43, “Шарын гол” ХК-ийн 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын 01 дүгээр тогтоол, тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 8 дугаар сарын 22-ны 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Шарын гол” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог нийт 1,707,404 /нэг сая долоон зуун долоон мянга дөрвөн зуун дөрөв/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэн тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,231,389 /арван сая хоёр зуун гучин нэгэн мянга гурван зуун наян ес/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/-т үүрэг болгож, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Дээрх нэмж гаргаж буй энгийн хувьцааны компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах санал болгох үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоолыг үндэслэн 11,117 /арван нэгэн мянга нэг зуун арван долоо/ төгрөгөөс доошгүй байхаар тогтоохыг зөвшөөрч, энэхүү тогтоолын 1-д заасан хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлж, энэ тэргүүн ээлжинд худалдан авах саналыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш хуульд заасан хугацаа, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Шарын гол” ХК /С.Насанбат/, “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

3. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд санал болгон захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд санал болгох доод үнийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу 11,117 /арван нэгэн мянга нэг зуун арван долоон/ төгрөгөөр тогтоохыг зөвшөөрсүгэй.

4. Нэмж гаргаж буй хувьцааг “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгох, нийтэд санал болгон арилжаалах ажиллагааны дүнд төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай 17,748,464,580 /арван долоон тэрбум долоон зуун дөчин найман сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга таван зуун наян/ төгрөгийн 80-аас доошгүй хувийг төвлөрүүлж чадсан нөхцөлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

5. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг худалдан авах хүсэлтийг хүлээн авч дуусгах, нэгдсэн бүртгэл гарган худалдан авсан үнэт цаасыг өмчлөх эрхийг шилжүүлэх үнэт цаасны арилжааг олон нийтэд санал болгон гаргах анхдагч зах зээлийн арилжаатай зэрэг зохион байгуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д, “Шарын гол” ХК /С.Насанбат/-д, “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын 3-т заасан мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх боломжтой болсон тохиолдолд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан хийгдэх уг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зогсоох, “Шарын гол” ХК-ийн нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг Хороонд ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д даалгасугай.

7. Энэ тогтоолын 1-д заасан хувьцааг нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээлд гаргасан өдрөөр тасалбар болгон “Шарын гол” ХК-ийн том хувьцаа эзэмшигчид болох “Файрбөрд Глобал Мастер Фанд” ХХК, “Файрбөрд Глобал Мастер Фанд II” ХХК, “Файрбөрд Монголиа Фанд”, “Шарын гол Энерго”, “Могоул ресорсес” ХХК-иудын өмчлөл дэх “Шарын гол” ХК-ийн энгийн хувьцаануудыг тус бүр хоёр жилийн хугацаагаар тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК /Г.Гандулам/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 6 дахь заалтаар тусгаарлалт хийсэн нь нэр дурдагдсан 5 хувьцаа эзэмшигчдийн хооронд хийгдэх үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх ажиллагааг хязгаарлахгүй болохыг тэмдэглэсүгэй.

9. “Шарын гол” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

10. Тус компанийн нэмж үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Шарын гол” ХК /С.Насанбат/, “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай:

1/ энэ тогтоолын 1-д заасан 1,707,404 /нэг сая долоон зуун долоон мянга дөрвөн зуун дөрөв/ ширхэг хувьцаа гаргах тухай үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн үнэ төлбөргүйгээр олон нийтэд нийтлэг мэдээлэл хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ үнэт цаасны танилцуулгад заасан хуваарийн дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох ажлыг зохион байгуулж, арилжаалагдаагүй үлдсэн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасуулах эсэх асуудлыг Хороонд тавьж шийдвэрлүүлэх;

3/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох баримтын хамт Хороонд ирүүлэх.

11. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007-оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Шарын гол” ХК /С.Насанбат/-д үүрэг болгосугай.

12. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд үнэт цаас худалдсаны орлого буюу үнэт цаас гаргагч “Шарын гол” ХК-ийн дансанд байршсан мөнгөн хөрөнгийг тус компани хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг

шинэчилсэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг захиран зарцуулах болон удирдлагын бүтцэд өөрчлөлт орох талаар холбогдох шийдвэрийг гаргаж тус Хороонд ирүүлэх хүртэл хугацаанд тусгаарлахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

13. “Шарын гол” ХК-ийн нийтэд санал болгон худалдсан үнэт цаасыг худалдан авсан хувьцаа эзэмшигчдийн тус компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрхийг хангах зорилгоор Хорооны 2008 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хурлын зар мэдээг хүргэх тухай журам”-ын 2.6 дахь заалт тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зохион байгуулахад үйлчлэхгүй болохыг тогтоож, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэлийн өдөр”-ийг хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах өдрийн өмнөх өдөр байхаар тогтоосугай

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

2011.10.13

1263

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-Д**

ҮНЭТ ЦААС ХАДГАЛУУЛАХ МЭДЭГДЭЛ № 309-д

НЭМЖ ҮНЭТ ЦААС БҮРТГЭХ ТУХАЙ

СЗХ-ны 2011 оны 08-р сарын 24-ний өдрийн №250 тоот тогтоол, МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2011 оны 10-р сарын 11-ны өдрийн №127 тоот тушаалыг тус тус үндэслэн Төвлөрсөн хадгаламжид дараах өөрчлөлт оруулахыг мэдэгдье.

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ
Үнэт цаасны нэр:	“Шарын гол” ХК
Үнэт цаасны төрөл:	Хувьцаа
Үнэт цаасны хэлбэр:	Энгийн
Нэгжийн нэрлэсэн үнэ: /төгрөг/	100
Одоогийн бүртгэлтэй үнэт цаасны тоо: /ширхэг/	8,523,985
Нэмж гаргаж буй үнэт цаасны тоо: /ширхэг/	1,707,404
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	10,231,389
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	1,023,138,900



Х.АЛТАЙ

М.ЭНХТУЯА

Үнийн дүн: 852,398,500 төгрөг

Нэмж бүртгүүлэх үнэт цаас:

Хувьцааны тоо ширхэг: 1,707,404 ширхэг

Нэмж гаргах хувь /Одоогийн хувьцаанд эзлэх хувь/: 16,69 %

Нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Зах зээлд санал болгох үнэ: 11,117 төгрөг

Санал болгох хүрээ: Хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд, захиалга биелэгдэхгүй бол нийтэд санал болгох

Шаардлагатай хөрөнгө оруулалтын дүн: 18,045,754,808 төгрөг

Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн: 17,748,464,580 төгрөг

Өөрийн хөрөнгөөр санхүүжилт хийх дүн: 297,290,288 төгрөг

Нэмж гаргаж буй хувьцааны зах зээлд арилжигдах боломжит ханшийг “Пантеон” ХХК нь үнэт цаас гаргагчийн хувьцааны сүүлийн 24 сарын дундаж ханш, бусад харьцуулсан судалгаанд үндэслэн тогтоосон ба уг үнэ ханшийг үндэслэн “Шарын гол” ХХК-ийн ТУЗ-ийн 2011 оны 8-р сарын 22-ны өдрийн 18 тоот тогтоолоор хувьцааны доод үнийг **11,117 төгрөгөөр** тогтоосон байна.

Арилжих хэлбэр:

Компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд санал тавьж, худалдан авах эрх хэрэгжээгүй тохиолдолд олон нийтэд захиалгын бүртгэлийн аргаар санал болгон арилжихыг Хорооны тогтоолоор тодорхойлсон.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ:

Үйл ажиллагааг сайжруулах, техник технологийн шинэчлэл болон засвар үйлчилгээ хийх, эргэлтийн хөрөнгө болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хангахын тулд компанид нийт 18.04 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна. Үүний 98.3 % буюу 17.74 тэрбум төгрөгийг үнэт цаас нэмж гаргах байдлаар, үлдэх 0.29 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Компани нь татан төвлөрүүлэх хөрөнгийг дараах зүйлд зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

Зарцуулалт	Үнийн дүн	Хувь	Тайлбар
Уулийн техник шинэчлэл	6,756,120,000	37,4 %	Нүүрс болон хөрс тээврийн ачааны машин, өрөмдлөгийн машин, эксковатор, бульдозер
Үйл ажиллагааны зардал	4,568,215,208	25,3 %	Файрбөрд санд төлөх өр төлбөр, ТЭЗҮ зөвөлгөө, зардал, шинэ карьерын олборлолтын зөвлөх үйлчилгээ, гадаад мэргэжилтний хөлс, нэмж гаргаж буй хувьцааны аудит, үнэлгээ, андеррайтер, арилжааны шимтгэл, хууль зүйн дүгнэлтийн ажлын хөлс болон бусад үйл ажиллагааны зардал
Засвар ба үйлчилгээний баазын шинэчлэл	3,662,820,000	20,3 %	Засварын суурин тоног төхөөрөмжийн шинэчлэл, цахилгаан эксковаторуудын их засвар, сэлбэг, уурхайн болон авто замын засвар шинэчлэл, автокран, автогрейдер
Хэсэг нэгжүүдийн ажлын байрны засвар, багаж тоноглолын шинэчлэл	1,413,720,000	7,8 %	Амралт, зуслангийн хотхон, спорт залны засвар, захиргааны барилгын дээврийн засвар, программ хангамж, нүүрсний лабораторийн шинэчлэл, хэсэг нэгжүүдэд тоног төхөөрөмж
Нүүрс ангилан ачих хэсгийн шинэчлэл	1,183,140,000	6,6 %	Конвейр, бутлагч, ангилан ачилтын шинэчлэл, өргөтгөл
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайжруулах	461,739,600	2,6 %	Аюулгүй ажиллагааны сайжруулалт, хамгаалалтын хувцас, хэрэгсэл, угаалга, халуун усны байгууламж, ажилчдын

			автобус, камерын хяналтын систем
НИЙТ	18,045,754,808	100%	

Шаардлагатай санхүүжилтын бүтцийг авч үзвэл нийт хэрэгцээний 64.3% нь техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, 10.4 % нь хөдөлмөр хамгаалал, ажлын байрны нөхцөл сайжруулалтад, 25.3% нь үйл ажиллагааны болон бусад зардалд шаардагдаж байна.

ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР, ШААРДЛАГА ХАНГАЖ БАЙГАА БАЙДАЛ

Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зүйлд заасан бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангаж байгаа эсэхэд шалгалт хийхэд дараах байдалтай байна.

Шалгуур:

№	Шалгуур үзүүлэлт	Ерөнхий шалгуур үзүүлэлт	2010.12.31	2011.06.30
1	Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө	10.0 саяас дээш	7,8 тэрбум	13,9 тэрбум
2	Бүртгүүлэх үнэт цаасны үнийн дүнд эзлэх эргэлтийн бус хөрөнгийн хэмжээ	10-аас доошгүй хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлнэ.	1656 %	1790 %
3	Бүртгүүлэх үеийн хувьцаа худалдан авах захиалагчийн тоо	50-иас цөөнгүй байх	623	1044
4	Нэмж гаргаж буй хувьцаанаас олон нийтэд санал болгох хувь	30-с доошгүй хувь	Тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшигчдэд 100%	
			17.04 %	14.23 %
5	Үйл ажиллагаа эрхэлсэн жил	1 жил	45 жил	46 жил
6	Ашгийн хэмжээ	Ашигтай байх, Хэрэв алдагдалтай бол алдагдлын хэмжээ нь өөрийн хөрөнгийн 30%-иас илүүгүй байх	215,0 сая төгрөг	670,3 сая төгрөг

МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ийн шалгуур үзүүлэлтийг “Шарын гол” ХК-иас ирүүлсэн материалд тулгуурлан тогтооход тус компани нь журмаар тавигдах шалгуурыг бүрэн хангаж байна.

Шаардлага:

д/д	Шаардлага	Хангаж буй байдал
1	Үнэт цаас гаргагч нь Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, эрх бүхий этгээдийн батлан гаргасан журам, заавар, гэрээг дагаж мөрдөн, хөрөнгө оруулагч, болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана.	+
2	Үнэт цаас гаргагчийн удирдлага нь компанийн бизнесийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдаж, хөрөнгө оруулагч, хамтрагч нарын эрхийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, удирдамжийн дагуу өөрийн компанийн засаглалын журам, дүрмийг батлан мөрдөж болно.	+
3	Үнэт цаастай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хувьцаа эзэмшигч, мэргэжлийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий үнэт цаас хариуцсан ажилтантай байна.	+
4	Үнэт цаасны гүйлгээ, үнэ ханш, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээ, компанийн болон удирдлагын үйл ажиллагааны талаар хувьцаа эзэмшигч болон МХБ-д шударга, шударгаар ил тоо хураана.	+